




ӨМНӨГОВЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Өмнөговь
политехник
колледж



ЧАДАМЖИЙН
ТӨВ


Өмнөговь Политехник Коллежийн
багш нарын дунд зохион байгуулсан
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БҮТЭЭЛИЙН
ЭМХЭТГЭЛ

Өмнөговь Политехник Коллежийн багш нарын дунд зохион байгуулсан ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ЭМХЭТГЭЛ

Даланзадгад
2022 он



ӨМНӨГОВЬ
ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ



Өмнөговь
политехник
колледжийн

Өмнөговь Политехник Коллежийн
багш нарын дунд зохион байгуулсан

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ЭМХЭТГЭЛ

Эрдэм шинжилгээний
бүтээлийн эмхэтгэл

Даланзадгад
2022 он



**ӨМНӨГОВЬ
ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ**



Бүтээлийн эмхэтгэлийг хянасан: Б.Баярмаа
Эхийг бэлтгэсэн: З.Цэрэндагва

Хуудасны хэмжээ: 148х210 мм
Хэвлэлийн хуудас: 9.5 х.х
Хэвлэгдсэн тоо:ш

Даланзадгад
2022 он



АГУУЛГА

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬД “ОЛОН ТАЛТ” СУДЛАГДАХУУНЫ ХАНДЛАГЫГ БИЙ БОЛГОХ НЬ	
Багш Б. Гэрэлмаа	5
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД	
Багш Х.Эрдэнэсайхан	15
СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХАД СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН НӨЛӨӨЛӨХ НЬ	
Багш Б.Лхамсүрэн, Н.Мөнхцэцэг	23
СУРАЛЦАГЧДЫН СУРЛАГЫН ЧАНАРТ ЦАХИМ ХИЧЭЭЛ НӨЛӨӨЛӨХ ҮҮ?	
Багш Ч.Зулзага, З.Цэрэндагва	34

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬД “ОЛОН ТАЛТ” СУДЛАГДАХУУНЫ
ХАНДЛАГЫГ БИЙ БОЛГОХ НЬ

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД НӨЛӨӨЛӨХ
ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД

СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХАД СУРГАЛТЫН
ХЭРЭГЛЭГДЭХҮҮН НӨЛӨӨЛӨХ НЬ

СУРАЛЦАГЧДЫН СУРЛАГЫН ЧАНАРТ
ЦАХИМ ХИЧЭЭЛ НӨЛӨӨЛӨХ ҮҮ?



**ӨМНӨГОВЬ
ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ**

ᠣᠮᠨᠦᠭᠣᠪᠢ
ᠯᠢᠮᠢᠲᠡᠬᠡᠨᠢᠭ
ᠴᠣᠯᠡᠵᠡ



АЛСЫН ХАРАА (OUR VISION)

Олон улсын түвшинд хүрсэн сургалтын үйлчилгээ бүхий мэргэжлийн боловсрол сургалтын загвар сургууль болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО (OUR MISSION)

Сургалтын үйлчилгээний чанар хүртээмжийг тасралтгүй сайжруулж, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн, хүний эрх, байгаль орчинд ээлтэй салбартаа манлайлагч мэргэжилтэй ажилтанг бэлтгэнэ.



МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬД “ОЛОН ТАЛТ” СУДЛАГДАХУУНЫ ХАНДЛАГЫГ БИЙ БОЛГОХ НЬ

Багш Б. Гэрэлмаа
Өмнөговь Политехник коллежийн химийн багш

Түлхүүр үг: “ОЛОН ТАЛТ” судлагдахууны хандлага
STEM /Science, Technology, Engineering, Mathematic/ хичээл
Сургалтын хөтөлбөрийн хичээл хоорондын интеграци

ОРШИЛ

Өнөөгийн хүүхэд залуучууд Техник Технологийн эрчимтэй хөгжлийн нөлөөгөөр хурдацтай өөрчлөлт бүхий өрсөлдөөнтэй, цаашдын хөгжил нь тааварлашгүй нийгэмд өсөн бойжиж, сурч, мэргэжлийн ур чадвар эзэмшиж, ажиллаж амьдарцгааж байна.

Энэ цагийн боловсролын асуудал нь шинэ зуунд суралцагчдын эзэмших боловсрол, сурах арга барилыг дахин нягталж үзэхийг шаардаж байна.

Мэдээллийн эрин зуунд суралцагсдыг төлөвшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь хичээл хоорондын интеграцийг шинэлэг байдлаар шийдэх хэрэгцээ бий болж байна.

Сүүлийн үед Цогц чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг бий болгох чиглэлд их анхаарч суралцагсад амьдралын эргэн тойрноос амжилттай мэдлэг олж чадаж байна уу? Мэдлэгээ ажил практикт бүрэн ашиглаж чаддаг уу? Хэт олон онолын хичээлээр дараад байгаа юм биш гэх зэрэг асуултууд зүй ёсоор гарч ирж байна.

Судалгааг: Зорилтод бүлгүүдтэй ярилцлах, суралцагчдаас судалгаа авах
Даланзадгад сумын ЕБСургуулиудын сургалтын цөм хөтөлбөрт анализ хийх
Өмнөговь аймгийн ПТК-н Хоол үйлдвэрлэл, Мужаан, Үсчин гоо сайхан, Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн ангиудын сургалтын төлөвлөгөөнүүдийн хичээлийн цагийн нягтралд тооцоолол хийх

Коллежийн Хими, Биологи, Физикийн хичээлүүдийн цөм хөтөлбөрийн агуулга, хичээлийн цагт анализ хийх, харьцуулах, жиших зэрэг аргуудыг ашиглалаа.

Сэдэв сонгосон үндэслэл:

Мэргэжлийн боловсрол нь нийгмийн харилцааны хамгийн том зах зээл болох хөдөлмөрийн зах зээлтэй шууд холбоотой, нийгэм хүмүүнлэгийн болон эдийн засгийн томоохон ач холбогдолтой нийгмийн бүх гишүүдэд ашгаа өгдөг онцлог

МОНГОЛЫН
ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН
ХИМИЙН
БАГШ



салбар юм.

Өнөөдөр мэргэжлийн боловсролын хөгжлийн түвшнийг хэмжих гол хэмжүүр нь түүнд зарцуулж байгаа хөрөнгө мөнгө бус, сургууль төгсөгчдийн тоо ч биш, харин бэлтгэгдэн гарч байгаа хүмүүсийн ажил эрхлэлт, тэдний төлөвшил нийгэмд эзэлж буй байр суурь, цаашилбал олж авсан мэдлэг, чадвар, мэргэжил нь амьдрах баталгаа болж чадаж байгаа эсэхээр тодорхойлогдоно.


Өнөөгийн Боловсролын хөгжлийн шинэ хандлага нь Боловсролын тогтолцоог хувирган шинэчлэх, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нийцүүлэн суралцагчийн цогц чадамж, ур чадвар, зэргээр олон янзаар нэрлэж байгаа боловч, тэдгээрийн нийтлэг нэг зүйл бол **суралцагчдад ирээдүйн амжилтад хүрэхэд юу тусладаг вэ?** гэсэн асуултын хариулт дээр төвлөрч байна.

Мэдлэг чадварын хадгалагдах болон хэрэглэгдэх хугацаа улам бүр богино болж, хувь хүнээс хандлага зан чанар, сэтгэл хөдлөл, сэдэл зэрэг олон зүйлийг цогцоор нь шаардах болсон шинэ зуунд ЮНЕСКО болон бусад олон улсын боловсролын судалгааны байгууллууд цогц чадамжид суурилсан боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлалыг тунхаглаж, улс орнууд тэр дундаа Монгол улс тэрхүү боловсролыг бүтээхийг зорьж байна.

Судлаач миний хувьд өөрийн сургуулийн Х-р ангийн 172, XI-р ангийн 200 гаруй суралцагсдад Химийн хичээл ордог бөгөөд тэднээс:

Мэргэжлийн сургуульд элсэх болсон шалтгаанаа бичнэ үү гэсэн асуулга авахад:

Мэргэжлийн сургуульд шинээр элсэгчдээс авсан судалгаа



■ Асуулт 1 ■ Асуулт 2 ■ Асуулт 3 ■ Асуулт 4

- Сонирхсон мэргэжлээрээ сурахын зэрэгцээ ЕБС төгсөх боломжтой байдаг тул 43,2 %
- Шаталсан сургуульд элсэхийн тулд:-19,6 %
- Давхар мэргэжил эзэмшиж цаг хожихын тулд-26,2 %
- Эцэг эхийн шаардлагаар-11% гэж хариулсан нь мэргэжлийн ур чадвараас гадна суурь мэдлэг чадвар хэрэгтэй байгааг ухамсарласан явдал юм.



A 3D bar chart with a vertical axis ranging from 0 to 45 in increments of 5. There are four red bars representing different categories. The values for each bar are labeled on top: 40, 26, 20, and 10.

Category	Value
1	40
2	26
3	20
4	10

10%-хүндрэлтэй бус

Багш нарын хувьд өөр өөр хичээл заадаг учраас цагийн энэ нягтралыг тэр бүр анзаардаггүй нь харагдаж байна.

Сургалтын агуулга нь давхардсан хичээлүүд байна уу? Салбар хоорондын интеграци хийх боломж байна уу? Олон талт судлагдахууны хандлагыг бий болгох боломж байна уу? гэсэн асуудлууд уг судалгааг хийх үндэслэл болсон.

- Мэргэжлийн боловсролын сургалтын чанарыг сайжруулах арга замыг тодорхойлох,
- ”Олон талт” судлагдахууны хандлагыг сургалтад бүтээлчээр хэрэгжүүлэх,
- Одоогийн хичээлийн цагийн ачааллыг багасгах, давхардсан агуулгыг нэгтгэх
- Судлагдахуун хоорондын интеграцид суурилсан хөтөлбөр бий болгох.

Ингэснээрээ суралцагчдын цогцоор сэтгэх,эргэцүүлэн бодох,шинжлэн судлах,бүтээлч чадваруудыг хөгжүүлж,олж авсан мэдлэгээ өөрсдийн амьдралын бүхий л хүрээнд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх арга замыг бий болгоно.



Зорилт:

- Мэргэжлийн боловсролын сургалтын байгуулгыг сонгон суралцагчдаас судалгаа авах
- Суралцагсдын хичээлийн цагийн ачааллын судалгааны анализ
- Хичээлүүдийн давхардсан агуулгыг нэгтгэх
- Нэг судлагдахууны олон салбарын мэдлэг шаардсан асуудал,нарийн төвөгтэй нөхцөл байдлыг шийдэх
- Багаар хамтран Интеграцид суурилсан сургалтын хөтөлбөр бий болгох


Үндсэн хэсэг:

Өмнөговь аймагт сүүлийн жилүүдэд уул уурхайн томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж тэнд ажиллах мэргэжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээ нэмэгдэж ирсэн.

Уул уурхайн техникийн мэргэжилтний хэрэгцээ хэдийгээр их байгаа ч бусад технологийн мэргэжлүүд болох Оёдол, Үсчин, Тогооч, Барилгын мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ давхар өсөж байна.

Судалгааны хэсэг:


1. 2021-2022 оны хичээлийн жилийн Мэргэжлийн ангиудын /Хоол үйлдвэрлэл, Үсчин, Мужаан, Барилгын сантехникч/ Сургалтын төлөвлөгөөнд тусгасан суралцагсдын нэг 7 хоног буюу 5 өдрийн хичээлийн цагийн ачааллыг харьцуулж үзэхэд:




Мэргэжлийн ангиудын сургалтын төлөвлөгөөг судалж үзэхэд жилийн сургалтын цаг нь 3475-аас 3546 байгаа бөгөөд Бүрэн дунд боловсролын агуулга нь 1458, Мэргэжлийн боловсролын агуулга 2178, Нийт судлах цаг 3725 байгаа нь суралцагчдын нэг өдрийн хичээлийн цаг 8-аас 10 цаг байгаа нь ачаалал өндөр байгааг харуулж байна.

2. Суралцагсдаас ПТК ийг төгсөөд яах бодолтой байгааг тандах асуултаар:
 - А-аль нэг дээд сургуульд элсэх-26,0%
 - Б-шаталсан сургуульд элсэх-21,7%
 - В –мэргэжлээрээ ажиллах-52,3%

Суралцагчдаас авсан судалгааны график



1. ЕБС-ийн аравдугаар ангид сурч байгаа үс тэнгийнхнээсээ юугаараа давуу, юугаараа дутуу гэж үздэг вэ?
 - Давхар мэргэжил эзэмших байгаагаараа давуу-26%
 - Шаталсан сургуульд үргэлжлүүлэн суралцдагаараа давуу-22%
 - Цаашид мэргэжлээрээ ажиллах боломжоороо давуу-52%



Үйл ажиллагааны туршлага:

Манай сургуульд суралцагсдын хувьд мэргэжлийн ур чадварыг сайн эзэмшихийн зэрэгцээ, хувь хүний харилцаа, ажлын ачаалал даах болон багаар ажиллах чадвар зэргийг хөгжүүлэх нь нэн тэргүүний асуудал болоод байна. Ажил олгогчдын эрэлт хэрэгцээн дээр үндэслэн суралцагчдын хандлага, харилцаа хувь хүний төлөвшилийг бүрдүүлэх чанарыг сайжруулахын тулд нилээд ажлуудыг зохион байгуулж байна.

Манай сургуулийн багш нарын хувьд 7 хоногт 16-34 цагийн хичээл зааж байгаа нь нэлээд ачаалалтайд тооцогдож байна.



Тиймээс багш суралцагчдын цагийн ачаалалыг багасгах, боловсролын бодлогыг хэрэгжүүлэх үр өгөөжтэй арга зам, суралцагчийн эзэмших мэдлэгийг ямагт хэрэглээтэй холбох, идэвхжүүлэх, оролцоог хангах, мэдлэг чадвараас гадна хандлага төлөвшилийг үнэлэх нь зайлшгүй чухал болж байна.

Судлагдахуун хоорондын хандлага нь сэдэв үзэл бодлын талаархи ойлголтуудыг бий болгож, өөр өөр судлагдахуун хоорондын холбоо, тэдгээрийн бодит ертөнцийн зүй тогтол, хамаарлыг холбож өгдөг сургалтын хөтөлбөрийн агуулгад интеграци хийх арга юм.

Салбар хоорондын интеграци нь гол төлөв хоёр ба түүнээс дээш тооны шинжлэх ухааны хичээлийг нэгтгэхээс гадна бусад хичээлийн янз бүрийн хэрэглээгээр шинэ сэдвийг бий болгох хоорондын хамтын ажиллагаа, хоорондын харилцаа юм.

Судлагдахуун хоорондын интеграцид суурилсан сургалт нь суралцагчдыг шинэ эрэл хайгуул, судлах үйл ажиллагаанд татан оролцуулж, тэдэнд мэдлэг, ойлголт, бэрхшээлийг шийдвэрлэх, өөртөө итгэх итгэл, суралцах хүсэл эрмэлзлэлийг бий болгож, шүүмжлэлтэй сэтгэх, ёс сурдхуундаа анхаарах, үнэлэх зэрэг хандлагыг төлөвшүүлэн хөгжүүлдэг зэрэг давуу талтай.

Олон талт судлагдахууны хандлага нь судлах сэдэв, шийдэх асуудлыг өөр өөр хичээлийн үүднээс судладаг сургалтын хөтөлбөрийг нэгтгэх хандлага юм.


Энэхүү хандлага, арга барил нь нэг судлагдахууны хил хязгаараас давсан олон салбарын мэдлэг шаардсан асуудал, нарийн төвөгтэй нөхцөл байдлын шийдэлд хүрэхэд тустай.

Судлаачид сургалтын хөтөлбөрт “олон талт” ажил мэргэжлийн асуудалд “салбар хоорондын” гэсэн нэр томъёог ашигладаг.

Яагаад хичээл хоорондын холбоо зайлшгүй хэрэгтэй вэ?

- Байгаль нийгмийн бүх үзэгдэл нэгдмэл шинжтэй бөгөөд бид тэдгээрийг сэрж мэдрэхдээ ч ямар нэг түвшинд нэгдмэл уялдаа холбоотой байдлаар нь тусгадаг.
- Хүмүүний үйл ажиллагаа нь сурч боловсрохын зорилго нь эзэмшиж байгаа мэдлэг чадвар нь нэгдмэл шинж чанартай байх шаардлагатай.
- Хүний сэтгэц танин мэдэхүйн үйл явц нь нэгдмэл бүтэц зохион байгуулалттай байдаг. Сэтгэхүйн үйл, үйлдлүүд дангаараа танин мэдэхүйн тодорхой төгсгөлөг үр дүнд хүрэхгүй, гагцхүү бие биетэйгээ уялдсан эрэмбэ дараатай тогтолцоонд орж, зөв оновчтой гүйцэтгэсний эцэст тодорхой үр дүнд хүрдэг. Гэтэл эдүгээ хүртэл бид юмс үзэгдлийг, тэдгээрийн шинж чанарыг хэтэрхий дагнан ганцаарчилж, идеалчилж судалж ирснээс суралцагсдын эзэмшсэн мэдлэг нь гүн бат бус, чадвар нь хэрэглээнээс хөндий байгаа билээ.

Сургалтын агуулгын холбоо



Боловсролын сургалтын төлөвлөгөөнд үндсэн хичээлүүдийг, судлах цагийн хамтаар зааж өгдөг.

Тэдгээр хичээл нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд бусад судлагдахууныг хамруулж оролцогчид мэдлэг солилцож үр дүнг харьцуулдаг боловч тухайн нэг судлагдахууны хүрээнд л онцлог байдлаа хадгалж үлддэг.

Уламжлалт сургалт нь ижил зорилт, шаардлагын дор нийтийг хамарч явагддаг.

Суралцахуйн үр дүн нь агуулгыг эзэмшихэд чиглэгддэг. Сургалтын агуулгаа эзэмшсэн эсэхээс үл хамааран тогтоосон хурдаар/багшийн/урагшилдаг. Суралцах арга зүйг багш боловсруулж удирддаг.


Жишээ нь: X, XI ангийн Химийн хичээлийн эслэг ба мяндас, уураг сэдвүүдийн салбар хоорондын нэр томьёогоор судалж үзэхэд:



Эслэг буюу мяндас сэдвийн судлагдахуун хоорондын интеграци



Мэргэжлийн ба суурь



“Уураг” сэдвийн судлагдахуун хоорондын интеграци



Дүгнэлт:

- Олон талт судлагдахууны хандлага нь өөр өөр хичээлээр адил төстэй сэдэв судалж, сургалтын хөтөлбөрийг нэгтгэдэг бөгөөд энэ нь суралцагсдын цагийн ачааллыг багасгаж, тэднийг , шинэ эрэл хайгуул хийх судлах ажиллагаанд татан оруулах, тэдэнд нэгдсэн мэдлэг ойлголт өгөх, үр дүнтэй суралцах давуу талыг бий болгоно.
- Судлагдахуун хоорондын интеграцид суурилсан хөтөлбөр, STEM хичээл заах боломж бүрдэнэ.
- Суралцагсад нэг хичээлээр судлах тодорхой үзэгдлийг өөр, өөр хичээлийн мэдлэгийн үүднээс тайлбарлах чадвартай болно.
- Бодит асуудлыг олон судлагдахууны мэдлэгийг ашиглан шийдэж сурснаараа суралцагсад илүү хөгжих боломж нээгдэнэ.
- Мэргэжлийн болон Ерөнхий эрдмийн багш нарын хамтарсан үйл ажиллагааны үр дүнд, шинээр “Судлагдахуун хоорондын интеграцид суурилсан” сургалтын хөтөлбөр бий болгох боломж байна.



Ном зүй

Сургалтын төлөвлөгөөнүүд:

1. Өмнөговь аймаг дахь Политехник Коллеж Мэргэжил: Тогооч Мэргэжлийн индекс:IF 5120-11 Өмнөговь аймаг дахь Политехник Коллеж Мэргэжил: Үсчин Мэргэжлийн индекс:SO 5141-11
2. Өмнөговь аймаг дахь Политехник Коллеж Мэргэжил: Мужаан Мэргэжлийн индекс:IF 7115-22

Х, XI дүгээр ангийн сургалтын цөм хөтөлбөр:

3. Хими, Биолог, Физикийн хичээлийн цөм хөтөлбөр
4. Боловсролын Үнэлгээний Төв 2018. Боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан суурь боловсрол Улаанбаатар...
5. Боловсролын Үнэлгээний Төв 2019. Бүх нийтийн үнэлгээ төсөл. www.eec.mn
6. Оюунцэцэг, Н., нар 2017. 21 дүгээр зууны Монгол суралцагчийн компентецийн Судалгааны тайлан. Боловсролын хүрээлэн УБ.
7. Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй 2020 он.



МОНГОЛ
АКАДЕМИ
ОЛОН
УЛСЫН
ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ
БҮТЭЭЛИЙН
ЭМХЭТГЭЛ

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД

Багш: Х.Эрдэнэсайхан

УДИРТГАЛ

Түлхүүр үг

Сурах үйл: Ажиглах-эргэцүүлэх-төлөвлөх-үйлдэх

Z generation буюу шинэ мянганыхны дараа үеийнхэн: 1998-2012 онуудад төрсөн хүмүүсийг хамруулна. Суралцах хэв маяг нь технологит суурилсан.

Монголчуудын ахуй амьдрал өөрөө тэр чигээрээ үйлийн судалгаанд тулгуурлаж өдөр тутмын ажил амьдралаа шинжиж үйлийн явцдаа суралцаж ирсэн түүхтэй.

Тиймээс Монголчуудын үйлийн явцад суралцахуйн арга барилог шинжлэн судлах хэрэгцээ шаардлага байсаар байна. Энэ нь судлаач миний сонирхлыг татаж уг шаардлагын улмаас суралцагчийн суралцах үйл, олгогдож буй мэдлэгийн аргачлалын нийцлийг тодруулахаар зорин Монголчуудын үйлийн судалгааны талаарх онолыг орчин цагийн сургалтын талаарх онол болох бихевиоризмын онол, конструктивизм болон когнитивизм онолуудад тулгуурлан өөрсдийн сургалтын үйл явцад холбон тэдний суралцах хэв маягийн онцлогт зохицож буйг хэлэлцүүлж байгаа болно. Улмаар суралцагчид сурах үйлийг ажиглах-эргэцүүлэх-төлөвлөх-үйлдэх гэсэн дөрвөн орчлын хүрээнд зохих шаардлагыг Тодорхой түвшинд хангаж буй эсэхийг илрүүлэх явц юм.

Монголчууд эрт дээр үеэс үйл судлалд “шинжлэх үгүй бол мэдэх үгүй, шиншлэх үгүй бол үнэртэх үгүй, шимэх үгүй бол амтлах үгүй” хэмээн онцгойлон анхаарч ирсэн билээ гэж бичсэн¹.

Судлагдсан байдал

Үйлийн судалгааны тухай онол нь бусад дэлхий даяар түгэн дэлгэрсэн онолуудаас ялгарах онцлогтой.

- Үйл болон үйлийн судалгааны гүн нарийныг буюу утга, учир, уг чанар, ач холбогдол түүнийг зайлшгүй эрхлэх хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь тодруулах боломж олгодог
- Бусад онолуудаас нэг шат гүн буюу тэдгээрийн маш гүн нарийныг илрүүлдэг. Тухайлбал: Үйлийн судалгааны тухай эдүгээ цагийн онолууд

1 Академич Б.Жадамбаа “Үйлийн судалгааны квант онол”, 2016,х.44



алив бүхний мөн чанарыг тодруулан зүй тогтлыг тайлбарлан тодорхойлж байгаа бол Монголчуудын үйлийн судалгааны онол тэрхүү зүй тогтлын маш гүн нарийн нь тэдгээрийн мөн чанарын ёсонд, өөрөө болсон ёсонд байдаг болохыг хэлж өгдөг.

- Монголчуудын үйлийн судалгааны онолын үндэслэлүүд нь өнөөгийн түүний талаарх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүх онолуудыг болон тэдгээрийг баяжуулан хөгжүүлэх санаануудыг өөртөө агуулсан мета шинжтэй төрхтэй гэж үзсэн байна. /Б.Жадамбаа, 2016,х.11/ Швейцарын эрдэмтэн Ж.Пиаже 1960 оны үед хүний хөгжлийн сэтгэлзүйн тухай асуудлыг үндсээр нь өөрчлөхдөө дөрвөн том дүгнэлт хийсний нэг нь “Хүний хөгжил бол биологийн суурь чадавх болон туршлага” гэсэн хоёр зүйлийн үр дүн байна гэж тодорхойлсон байдаг /Баярмагнай ба бус.,2018, х.11/ гэжээ. Үүнээс үзэхэд аливаа зүйлийг сурахад олон дахин давтаж хийж үзсэний үр дүнд туршлага хуримтлуулж суралцан өөрийн арга барилыг бий болгосноор мэдлэгийн бүтцээ өөрчилж сайжруулан суралцах үйл явц явагдаж хүн хөгждөг гэж үзвэл “Хүн мэдлэгийг бусдаас дамжуулан хүртдэггүй харин өөрөө өөртөө зохиомжлон бүтээдэг” гэсэн ойлголттой яв цав нийцэж байна. Нэрт сэтгэгч Инжинаашийн “Зураг зурж сурахад гурван зүйлийн зам буй” Нэгэн зүйл нь “Багшийг дагаж ёсоор зурах”, өөр нэгэн зүйл нь “Бодитойг дагаж адил зурах”, гурав дах зүйл нь “Өөрийн сэтгэгдэлээс төрүүлэн зурах” нь Монголчуудын уламжлалт үйлийн явцад суралцахуйн онолын бас нэг үндэс болох юм.
- Түүнчлэн судлаач Ч.Пүрэвдорж өөрийн бүтээлдээ “Монгол нүүдэлчин бол зүгээр амьдраад байдаггүй, харин түүнд суралцаж байдаг. Учир нь байгалиас заяасан угийн сониуч чанараар хүний оюун ухаан ямагт элдэв асуулт тавьсаар байх бөгөөд энэ нь түүний информал аргаар суралцах эх үндэс болдог” /Ч.Пүрэвдорж, эмхт.2014,х.24/ Энэ арга нь амьдралд дээр алив зүйлийг ахин дахин туршиж үзэж үр дүнг өмнөхтэйгөө харьцуулан ажиглаж, эргэцүүлж, төлөвлөж дахин сайжруулж суралцдаг нь үйлийн явцдаа суралцахуй мөн билээ.

Судалгааны арга зүй

Өмнөговь Политехник Коллежийн 164 оюутан, 31 багш судалгаанд хамрагдсан. Судалгааг кейс ярилцлага болон асуулгын аргуудад тулгуурлан хийсэн болно.

Судалгааны зорилго

Үйлийн судалгааны ажиглах-эргэцүүлэх-төлөвлөх-үйлдэх гэсэн барилыг судлан нэгэн орчлын загвараар хамгийн өндөр жинтэй байгаа үйлийг тодруулах, бидний мэдлэг олгож буй аргачлал нь суралцагчдын суралцах хэв маягийн



ОНЦЛОГТ НИЙЦЭЖ БҮЙ ЭСЭХЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ОРШИНО.

Судалгааны зорилт


Суралцах үйлийн орчил, суралцуулах аргачлал нь сурах хэв маягийн шинжид тулгуурлах зарчим хэр дөхүүтэй байгааг тодруулах, боломжит саналыг дэвшүүлэх, тэдгээрийг эрэлхийлэх

Судалгааны ач холбогдол

Сурах үйлийн орчил, чадамж олгох аргачлалаа нэг уулзварт огтлолцуулахаар төлөвлөн чиглүүлж ажиллаж чадвал сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлөх тодорхой хүчин зүйлсийг бууруулахад түлхэц болох ач холбогдолтой

ҮНДСЭН ХЭСЭГ

График-1




Суралцагчдын бие даан сурсан зүйлс
/хувиар, давхардсан тоогоор/

Дээрх асуултад хоол хийх, юм оёх нэхэх, спортын төрлүүдээр хичээллэх, мод төмөр эдлэлээр эд зүйлс хийх хэсгүүдийг илүүтэй сонгосон нь мэргэжил сонголттой холбоотой байх талтай. Эдгээр сонгосон нэг зүйл дээр нь үндэслэн яаж сурсан тухай суралцах аргыг судлахад хүний хийж байгаа зүйлээс ажиглаж сурсан гэх бөгөөд энэ нь үйлийн судалгааны онолын хувьд нэг циклээр дуусаад байгаад бөгөөд үүнийгээ хийгээд сурчихсан гэж эндүү ташаа ойлголттой байгаа нь судалгаанаас ажиглагдаж байна.

Эргээд өөрийн хийснийг ажиглан засаж сайжруулах тал дээр ажиллаж 2-3 болон 4 удаа хийхэд суралцагч бүрэн сурсан байдаг. Иймээс манай суралцагчид өөрийн үйлийг эргэж ажиглаж сурах нь суралцах аргыг сайжруулж үнэн бодитой мэдлэг бүтээхэд чиглэгдэх талтай байна.



График-2




Сонгосон зүйлээ алхамаар гүйцэтгэдэг байдал
/хувиар/

Сонгосон нэг зүйлээ ямар алхамаар хийсэн бэ? гэсэн асуултад хүүхдүүдийн дийлэнх хувь нь буруу хариулт өгч байгаа нь яаж сурсан алхамаа мэдэхгүй байсантай холбоотой. Өөрийн сурсан зүйлээ ажиглах, үйлдэх, гэсэн 2 алхамаар хийж сурсан 92 хүүхэд байна. Үүнээс үзэхэд сурсан нэг зүйлийнхээ талаар яаж сурснаа алхамаар нь бичиж мэдэхгүй хэт ерөнхийлж үйл ажиллагааны дарааллыг бичсэн байснаас 51 хүүхэд ажиглаж байгаад сурсан гэж хариулсан бол мөн л 57 хүүхэд нь ажигласныхаа дараа шууд хийж сурсан гэсэн хариултаас харахад ажиглаад хийсэн байгаа нь эргэцүүлж бодох, төлөвлөх гэсэн 2 орчил нь хангалтгүй, өөрийн сурсан зүйлдээ эргээд сайжруулалт хийдэггүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Аливааг хийхдээ ажиглах, эргэцүүлэх, төлөвлөх, үйлдэх алхмаар гүйцэтгэдэг үү? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн илүүтэй хувь нь хийдэг гэсэн хариултыг өгөөд байна. Үүнээс үзэхэд гуравдугаар асуулттай нийцэхгүй байгаа бөгөөд энэ нь ямар алхмаар суралцаж байгаагаа бүрэн ухамсарлаагүй байна. Иймд дээрх 4 орчил цогцоороо байх нь зөв суралцах аргыг эзэмших үйл ажиллагаа болох бөгөөд нөгөө талаасаа аливаад бүтээлчээр хандах хандлагыг бий болгоход нөлөөлнө. Энэ нь сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга төлөвшөөгүй байгаа нь ажиглагдаж байна.

График-3



Сурсан зүйлээ хийж сурах хүртэл давтсан оролдлогын үзүүлэлт /хувиар/



കൂടെ കൂടിയിട്ടുണ്ട് എന്ന് പറയാൻ പറ്റും

Хэдэн удаагийн оролдлогоор хийж сурсан бэ? гэсэн асуултанд өөрийн сурсан зүйлийг ажиглаж сайжруулсан гэж 8 хүүхэд хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн суралцах арга дутуу төлөвшсөн байх талтайг харуулж байна. Хэдийгээр сурсан гэх боловч үнэндээ сайн сураагүй, эргэж сайжруулах өөрийн үйлийг ажиглах яаж сайжруулах тухай эргэцүүлж боддоггүй нь судалгааны дүнгээс ажиглагдлаа. Энэ нь уг графикийн үзүүлэлтийн 5-10 удаа буюу түүнээс дээш хийж сурсан гэж хариулсан баримтаас харахад батлагдаж байна.

Өөрийн ямар нэг сурсан зүйлээ бусаддаа түгээх, хэрхэн хуваалцах вэ? гэсэн асуултанд өөрийн биеэр хийж үзүүлж дараа нь өөрөөр нь хийлгэнэ гэсэн хариултыг дийлэнх нь өгсөн байгаа нь ажиглуулаад дараа нь хийлгэнэ гэсэн санаа бөгөөд энэ нь ажиглах үйлдэх 2 зарчмаар сургахаар төлөвлөж буй нь ажиглагдаж байна. Үүнээс харахад график 2-т үзүүлсэн баримттай нийцэж байгаа нь суралцах аргын хувьд төлөвшөөгүй байгаа бөгөөд өөрөө яаж сурсан тэр зарчмаар бусадтай мэддэг зүйлээ хуваалцах тухай хариулсан байна.

Дараагийн асуултанд сонгосон нэг зүйлээ ямар алхамаар хийсэн бэ? гэдэг асуултын хариултыг сайжруулах талаар дахин асуусан боловч эргэцүүлэх, төлөвлөх хоёрыг ойлгосон ч яаж сурснаа алхамаар нь бичиж чадахгүй хэвээр байсан.

Яагаад суралцагчид сурсан зүйлийнхээ алхамыг бичиж чадахгүй байгаа тал дээр эргэцүүлж бодоод кейс даалгавраар харьцуулж үзсэн.

Кейс: 1. 12 настай хүүхдээс хэнээр ч заалгаагүй сурсан зүйл байна уу гэж асуухад байна гээд нилээдгүй зүйлийг нэрлэсэн. Тодорхой хэдийг дурьдахад дугуй унаж, ролик унаж сурсан гэх мэт. Үүнээсээ дугуй яаж унаж сурсанаа хэлнэ үү гэхэд нэг бүрчлэн нэрлэж байсан төдийгүй өөрийн үйлийг ажиглаж сайжруулснаар чөлөөтэй унадаг болсон тухайгаа, ролик унаж сурсанаа ч ярьсан юм.

Ингээд судлаачийн зүгээс 12 настай хүүхэд хариулж байхад судалгаанд хамрагдсан суралцагчид яагаад алхамыг бичиж чадахгүй байгааг эргэцүүлэн суралцагчдаас кейс судалгаа авч харьцуулж үзэхээр болсон.

Кейс: 2 Суралцагч Д-ээс хэнээр ч заалгаагүй сурсан зүйл байна уу? гэж асуухад олон зүйлийг нэрлэсэн. Интернэтээс гитарын барилт хараад сурсан. Барилтаа сураад гитар дээрээ дуу оруулах гэхэд учраа олохгүй байсан. Өөр бичлэгүүд үзэн дахин ажиглалт хийсний үндсэн дээр барилт хоорондын шилжилт хамгийн гол зүйл гэдгийг олж харан 4-5 удаа болон түүнээс олон удаа давтсаны дараа шилжилт хийж сурсан гэж хариулсан.

Энэ кейсээс суралцагч Д-н гитарын барилт сурсан арга нь эхлээд ажиглаад, эргэцүүлээд үйлдсэн, дараа нь өөрийг үйлийг ажиглаж сайжруулаад олон удаа давтсаны үндсэнд барилтаа сурсан нь суралцагч Д-н хувьд төлөвлөх алхамыг орхигдуулсан байна. Нарийвчлан алхамчилж сурсан аргаа хэлж мэдэхгүй байгаа юм.



Ингээд 2 кейсийг харьцуулж үзэхэд бага насандаа хүүхэд юмыг сурахдаа их нарийвчилж өөрийнхөө сурах үйлийг ажиглаж алхамчилж сайжруулаад сурсан байхад суралцагч Д-гийн хувьд ерөнхийд нь ажиглаад эргэцүүлж хийсэн бөгөөд төлөвлөх алхамыг орхигдуулсан бөгөөд нарийн алхамчилж сурсан аргаа хэлж мэдэхгүй байсан. Үүнээс үзэхэд суралцагчдын суралцах арга нь тал талаараа хуваагдан салангид суралцах үйл явц явагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Таны олгож буй хичээлийн хэдэн хувь нь дэлгэц бүхий төхөөрөмж ашиглах болон цахимд суурилан явагдаж байна вэ? гэсэн асуултанд 62 хувь нь уг хэлбэрээр явагдаж байна гэж хариулсан байна.

Судалгаанд оролцсон багш нар өөрсдийн заагдаж буй хичээлийнхээ 41 хувьд нь суралцагчдыг багаар ажиллуулж байгаа нь тэднийг бие биенээс нь суралцуулах, хамтран ажиллах ур чадвараа нэмэгдүүлэх, бие биедээ хүлээцтэй хүндэтгэлтэй хандах, аливаа зүйлд шийдвэр зөв гаргахад тал бүрийн хамтын оролцоог ойлгуулах Зэрэг олон талын ач холбогдолыг сурах арга барилаараа дамжуулан олгосоор байгаа нь судалгаанаас ажиглагдаж байна.

График-4



Багийн ажлын оролцооны үзүүлэлт /хувиар/

Багийн ажлын оролцооны хамрагдалт боломжийн буюу дунд зэрэг гэсэн үзүүлэлт зонхилж байгаа нь нийт суралцагчид сургалтын орчинд болон хичээлийн цагаар суралцах үйлийн 4 орчил болох ажиглах, эргэцүүлэх, төлөвлөх, үйлдэх алхамыг орхигдуулахгүй хослуулаад цаашид сайжруулаад явах боломж харагдаж байна. Энэ нь хичээлийн зохион байгуулалт, төлөвлөлтийг хамтын болон багийн ажиллагаан дээр тулгуурлан явуулахад эрмэлзвэл ажил олгогчдын шаардлагыг тодорхой хувиар хангахад нөлөөлөх түлхэц болох талтай болов уу.

Асуулгын 4 дэх асуултанд суралцагчид биенээсээ суралцах, хөгжих боломж ажиглагддаг уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 93 хувь нь боломжтой гэж хариулт өгсөн байна. Энэ нь бид цаашид сургалтын хөтөлбөр төлөвлөлтөө боловсруулахдаа суралцагчдын нэг нэгнээсээ суралцах, хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвхөн хичээл заадаг багш илүүтэйгээр төлөвлөхөөс гадна энэ ажилд олон талт оролцоог хангахад анхаарал хандуулах нь зүйтэй байна. Ингэж нарийн зохион байгуулалттай ажиллаж чадвал хүүхдийг төлөвшсөн



хойно нь сурах арга барил эзэмшүүлэх гэж зүтгэх бус балчир ахуй насанд нь зөв сууриар дэмжээд явах хэрэгтэй байна. Энэ нь цаашлаад хандлага төлөвшлийг ажилд авах гэсэн ажил олгогчдын эрэлттэй нийцэх боломжтой юм.

Суралцагчдын гүйцэтгэж буй даалгавар, дасгал ажлын 87 хувь нь ном сурах бичиг, гарын авлага, тараах материалтай ажиллах даалгавар эзэлж байгаа гэж судалгаанд оролцогчид хариулсан байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнг задлан шинжилж нэгтгэн дүгнэсэнийхээ үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрлээ.

- Судалгаанаас үзэхэд суралцагчийн суралцах арга эмх цэгцтэй төлөвлөх үйл, өөрийн үйлийг шинжиж алдаагаа засаж сайжруулах тал дээр дутмаг байгаа нь ажиглагдлаа. Энэ нь бид хичээлийг хүргэхдээ суралцагчдад хичээлийг өөрөөр нь ажиглуулж, эргэцүүлэх, төлөвлөх, үйлдэх гэсэн 4 орчлыг эзэмшүүлэхэд анхаарах хэрэгтэй болов уу. Тухайлбал: Оёдлын ангийн суралцагчдад цамц оёх даалгавар өгөхдөө эхлээд багшийн гүйцэтгэж буй үйлдэл болон өмнөх туршлага бусад өөр төрлийн бичлэг зэрэг зүйлстэй жиших, технологи дараалал, хийц, материал зэрэг олон талаас нь ажиглуулах, мөн эргэцүүлэх алхамыг гүйцэтгүүлэх, улмаар эрэгтэй болон эмэгтэй хүний цамц хийхэд тэдний ялгаа онцлогийг хэрхэн тусгах тухай төлөвлөх, бусадтай хамтран болон бие даан даалгаврыг гүйцэтгэх зэрэг сурах үйлийг шатлан дамжуулж сургаж чадамж эзэмшүүлэхэд анхаарсан дасгал, даалгаврыг өгөх
- Суралцагчдын илүүтэй хувь нь сурах үйлийн 4 барилаас ажиглах- үйлдэх гэсэн алхамаар аливаа зүйлийг гүйцэтгэдэг тухай хариулт өгсөн нь эргэцүүлэх, төлөвлөх үеийг орхигдуулж сурах үйлийн шаталсан хэлбэр тасалдаж байгаагийн илрэл юм. Мөн аливаа зүйлийг олон удаа давтаж байж эзэмшиж чадсан тухай судалгааны дүнгээс харж болно. Иймд бид тус 4 орчлыг нэг шугаманд жигд явуулах, гол суурь чадамжуудыг эзэмшүүлэхэд дахин давтан гүйцэтгүүлэх болон ямар арга аргачлалаар тухайн суралцагчдад хүргэх боломжтойг шинжлэн тодорхойлж үр дүнд хүрэхэд чиглэх нь зүйтэй байна.
- Сургалтын явцад хүүхдийн төрөлх суралцах арга барил алдагдаад сурсан л гээд болохоос тухайн зүйлийг сайн сурч чадсан уу? гэдэгт өөртөө ажиглалт хийж нарийвчилж үзэхгүй орхигдуулж байна. Иймээс хүүхдийн сурах аргыг төлөвшүүлэхэд цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн түвшинд анхаарч үзэх шаардлагатай байна.
- Хүүхэд бага насандаа өөрийн төрөлх суралцах арга нь ажиглаж, эргэцүүлж, төлөвлөх, үйлдэх, мөн өөрийн үйлээ ажиглаад цаашид сайжруулаад сурч байгаа нь кейс судалгаанаас харагдаж байна. Харин 15-аас дээш насанд өөрийн сонирхолтой зүйлд илүү идэвхтэй суралцаж алхам бүрийг



ажиглаж сайжруулж сурч байгаа нь ажиглагдаж байна. Иймд бид дасгал ажил, даалгавраа суралцагчдын сонирхол, тэдний хэрэгцээтэй холбож өгч байвал тэдний гүйцэтгэлийн үр дүн сайжрах давуу талтай болов уу.

Санал зөвлөмж

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд тэдгээрийн нэгээхэн хэсэг болох суралцахуйн барицыг шатлан төлөвшүүлэхэд бүхий л боломжит хувилбаруудыг санал болгон тэдгээрийг дэмжсэн төлөвлөлт, арга аргачлалаа чиглүүлэх нь сурган хүмүүжүүлэгч бүрийн үүрэг болоод байна. Иймд 4 орчил цогцоороо байх нь зөв суралцах аргыг эзэмшүүлэх буюу тус онцлогийг харгалзан гүйцэтгэлд суурилан аливаад бүтээлчээр хандах хандлагыг бий болгоход нөлөөлөх чиглэл баримтлах шаардлагатай байна.
- Z үеийнхний онцлогт болон суралцах арга барилд тулгуурласан даалгавар, дасгал ажлууд бэлтгэн хүргэхэд анхаарах. Тухайлбал:
 - ✓ Сонсох арга барилтай суралцагчдад технологи дээр суурилсан богино хэмжээний сонсгох дасгал, харилцан ярианы дасгал
 - ✓ Харах арга барилтай суралцагчдад дижитал төхөөрөмж ашиглан үзүүлэн бэлтгэх, унших материалтай ажиллах даалгавар, дасгал ажил
 - ✓ Идэвхтэй арга барилтай суралцагчдад биетээр хийж турших, биеэр гүйцэтгэх боломж, нөхцөлийг хангасан дасгал даалгавар өгөх гэх мэт

Ном зүй

- М.Азжаргал, Ч. Сувд-эрдэнэ Сургалтанд сурах хэв маягийг ашиглах нь УБ., 2016.
- Б.Жадамбаа Үйлийн судалгааны квант онол УБ., 2016
- Ё. Нандинцэцэг Тогтолцооны хандлага ба боловсролын судалгаа УБ., 2014
- Ч.Пүрэвдорж Багшлахуйн менежмент УБ., 2014



судлан дүнг нэгтгэх

Судалгааны арга:

- Ажиглалт хийх
- Асуулга авах
- Туршилтын арга
- Ерөнхийлөн дүгнэх

Судалгааны таамаглал:

Хүн мэдрэхүйн эрхтнээрээ мэдээллийг сайн хүртдэг төдийгүй, ойлгож тогтоон санадгийн жишээ бол хүн ярьж илэрхийлсэн зүйлийг 2,8 сек; өнгөт фото зураг дээрх зүйлийг 0,9 сек; кинонд болон телевизээр гарч буй зүйлийг 0,7 сек; бодит байдлаар үзүүлсэн зүйлийг 0,4 секундэд тус тус хүлээн авдаг гэсэн судалгаа байдаг. Сүүлийн үеийн судалгаануудад сонсох эрхтнээр мэдээллийн 15%-ийг, харах эрхтнээрээ 25%-ийг хүлээн авах чадвартай байдаг бол хоёуланг нь хослуулан хэрэглэсэн үед 65%-д хүрдгийг нотолжээ. Иймээс хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглах нь сургалтын чанарыг дээшлүүлэх нэг боломж юм.

ОНОЛЫН ХЭСЭГ

Суралцагч бүрийг хөгжүүлэх явдал нь өнөө үеийн гол зорилго

Багш хаана байна тэр газар соёл, шинэчлэлт байх ёстой. Багш нь мэргэжлийн болон бичиг найруулга зүйн өндөр чадвар, математик сэтгэлгээ дүрслэх урлагийн мэдрэмжтэй байхаас гадна нийгмийн харилцааны болон хүний амьдралын чадваруудыг суралцагчдад эзэмшүүлж, зааварчилгаа өгөх чадвартай зөвлөгч байх хэрэгтэй

Мэргэжлийн боловсрол сургалтын газрын 2010 оны 12-р сарын 29 ны өдрийн 101 тоот тушаалаар Чадамжид суурилсан сургалтыг МБС -ын системд нэвтрүүлэх шийдвэр гарснаас монголын МБС-ын байгууллагууд энэхүү ЧСС-ын тогтолцоонд шилжсэн нь зөв оновчтой шийдвэр байсан.

Чадамж гэдэг нь аливаа ажлыг бие даан тодорхой түвшинд гүйцэтгэхэд шаардлагатай ажиглахуйц, хэмжигдэхүйц холбогдох мэдлэг ур чадвар болон зан байдал хандлагын иж бүрэн цогцыг бүрэн эзэмшсэн талаар дүрсэлсэн тодорхойлолт юм.

Манай сургалтад гарч буй үндсэн өөрчлөлтийн нэг бол сургалтын хөтөлбөр агуулгын өөрчлөлт. Бидний сургалтад хийх дараагийн өөрчлөлт бол багш төвтэй сургалтыг багш суралцагч гэсэн 2 тулгуурт процесс болгох явдал юм. Уламжлалт багш төвтэй сургалтад багш ярьдаг, сурагч сонсдог бол сурагч төвтэй сургалтад багш бага ярьж сурагч илүү их уншдаг боддог бичиж боловсруулдаг, ярьдаг, бүтээдэг байна.



Бүдүүвч №1




Сургалтад гарч байгаа дараагийн өөрчлөлт бол багш суралцагчдад бэлэн мэдлэг олгох өгөхийг гол зорилгоо болгох бус үүний оронд сурагчдад суурь мэдлэг, сурах арга барил, бүтээлч чадвар дадал төлөвшил хандлага хамтад нь эзэмшүүлэхийг гол болгож байна. Өөрөөр хэлбэл өнөө үед хичээл сургалт, сургалтын хэрэглэгдэхүүнээр сурагчид зөвхөн мэдлэг эзэмшээд зогсохгүй бас сурах арга барил чадвар, төлөвшлийг хамтад нь эзэмшиж авна.

Сургалтын бүтэц гэдэг бол сургалт хэмээх үзэгдлийг бүхэл бүтэн цогц зүйл болгож байгаа юмс үзэгдэл, тэдгээрийн холбоо хамаарал. Сургалтаар юугаар эхэлж юугаар дуусах вэ? Дээр өгүүлснээр сургалт багшаас эсвэл сурагчаас эхлэхгүй, эрэлт хэрэгцээнээс эхэлнэ. Одоо үед нийгмийн болон сурагчдын хэрэгцээг хослуулан хамтад нь хэрэгжүүлэх зорилт гарч ирсэн.

Хэрэгцээ нь сургалтын зорилго, агуулга хөтөлбөр, хэрэглэгдэхүүн багшийн сурах арга зүй сурагчийн сурах арга гэх зүйлээр дамжин хэрэгжих бөгөөд сурагчийн мэдлэг чадвар төлөвшилд гарсан ахиц өөрчлөлтийг хэмжиж тогтоох үнэлгээ, үр дүнгээр төгсөнө.

Дээр дурдсан зүйлийг дараах бүдүүвчээр үзүүлье.

Бүдүүвч №2





Сургалтын арга, хэрэглэгдэхүүн

Сургалтын хэрэглэгдэхүүн нь дээр дурдсан сургалтын зорилго, агуулгыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд багшийн сургах сурагчийн сурах үйл үйлдлээр дамжин хэрэгждэг. Ингэхдээ сургалтын хэрэглэгдэхүүн нь сурагчдыг идэвхтэй субъект байх, хэрэгтэй мэдлэгийг сурагч өөрөө эзэмшиж аваад зогсохгүй бас шинэ мэдлэг бүтээдэг субъект болгоход чиглэнэ. Жишээ нь сурагчийн бие даасан төрөл бүрийн ажил, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, хэлэлцүүлэг, дүрийн тоглолт, сурагчдаар мэдлэг бүтээлгэх аргуудыг өргөн хэрэглэнэ.

Сургалтад сурагчдын сурах үйл ажиллагааг идэвхжүүлэх нөлөөтэй янз бүрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой хэрэглэх шаардлага гарсаар байна. Жишээ нь тараах материал, үзүүлэн, дасгал бодлогын эмхтгэл, гарын авлага, тестийн эмхтгэл гэх мэт

Мэргэжлийн боловсролын багш бүр ээлжит хичээл дээр хэрэглэгдэхүүн хийх шаардлага гардаг.

Сургалтын хэрэглэгдэхүүн дараах зорилгыг хангана.

- Ажлын туршлага хуримтлуулах
- Суралцагчдад сонирхол төрүүлж идэвхжүүлэх
- Хамгаалах үйл явцыг тогтворжуулах
- Бодож, сэтгэхүйн явцыг дэмжих
- Суралцах үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх
- Цагийг бүтээлчээр ашиглах

Хэрэглэгдэхүүн хийхэд тодорхой хэмжээний цаг хугацаа болон хөрөнгө мөнгө шаардагддаг. Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга барилыг чадварлаг эзэмшсэн багш сурагчдыг хөгжүүлж чадна. Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд багшийн зүгээс хичээлийн бэлтгэл болох хэрэглэгдэхүүн хамгийн чухал.

Сургалтын хэрэглэгдэхүүний үндсэн үүргийг тодорхойлбол:


- Тодорхой юмс, үзэгдлийг шууд мэдрүүлэн мэдээлэл дамжуулах буюу танин мэдүүлэх;
- Суралцагчдын авьяас, сонирхол, зориг мэдрэмжийг хөгжүүлэх буюу төлөвшүүлэх;

Мэдлэгийг бататгах, таамаглах, таамаглал дэвшүүлэн шийдэх, хянан шалгах зэрэг дидактикийн үүрэг гүйцэтгэнэ. Сургалт нь дидактик зүйн үндсэн зарчим дээр үндэслэн явагддаг. Орчин үеийн сургах зүй нь сурган хүмүүжүүлэх үйл явцыг хүүхдийн сэтгэцийн хөгжил, хувийн онцлогтой нь уялдуулан, өнөөгийн боловсролын хөгжлийн дагуу хөгжүүлэх.

Сургалтын хэрэглэгдэхүүн нь аливаа үйлийг тодорхой зорилгод хүргэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны нэг хэлбэр билээ. Иймээс сургалтын хэрэглэгдэхүүн нь хөврөх чадвартай, сурагчдаас бүтээлч үйл ажиллагааг



Хэрэглэгдэхүүн гэж юу вэ? Хэрэглэгдэхүүн гэдэг нь сургалтын салшгүй нэгэн хэсэг бөгөөд тухайн хичээлийг амжилттай болгох бүхий л нөхцлийг хангадаг зүйл юм.



Сургалтын хэрэглэгдэхүүний давуу тал





Цахим хэрэглэгдэхүүн гэж юу вэ?

Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэхийн ач холбогдол юунд орших вэ?

- Сурагчид ойлгодог, мэдлэг гүн үлдэнэ.
- Сурагч бүрт хүртээмжтэй, хүүхэд бүрт хүрч ажиллах
- Мэдлэг бататгах
- Онолын мэдлэг бататгах
- Цахим ба бодис үзүүлэн аль нь өөрийн гэсэн давуу талтай
- Хичээлийг үр дүнтэй болгох, багшийн ажлыг хөнгөвчлөх
- Агуулгыг богино хугацаанд ойлгомжтой өгөх

Сургалтын дидактик шаардлагад нийцэхүйц боловсруулагдсан, компьютер болон бусад технологийн тусламжтайгаар суралцагчдад хүрч, сургалтанд хэрэглэгддэг нэгэн төрлийн хэрэглэгдэхүүн бол цахим хэрэглэгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл:

Цахим сургалт = технологид суурилсан сургалт

Цахим сургалтын томъёолол:

Энэ нь компьютерт суурилсан сургалт, вэбд суурилсан сургалт, виртуал сургалт, телевиз радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэгэн шинэ хэлбэр бөгөөд үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг.

Цахим сургалт нь суралцагчдад агуулгаа хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, хиймэл дагуулын систем, аудио, видео систем зэргийг ашигладаг.

Цахим хэрэглэгдэхүүнд тавигдах хэд хэдэн үндсэн шаардлага байдаг.

Үүнд:

- Түлхүүр буюу гол ойлголтоо оновчтой тодорхойлох.
- Өнгөний зохицолтой байх.
- Хөдөлгөөний эффект бүхий зураг, схем өргөнөөр ашиглах.
- Суралцагчийн идэвх оролцоог тооцож боловсруулах
- Хичээлээ нэгтгэн дүгнэдэг байх.

Үүнээс гадна цахим хэрэглэгдэхүүний элементүүдэд тавигдах шаардлага гэж



Сургалтын цахим хэрэглэгдэхүүн нь нэг талаасаа сургалтын оновчтой аргыг сонгон тухайн насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон бөгөөд хэрэгцээ шаардлагад тулгуурласан шавь төвтэй байх нөгөө талаасаа суралцагч бие даан суралцах бүхий л боломжийг олгодог байх хэрэгтэй.


- Бэлтгэсэн хэрэглэгдэхүүн товч бөгөөд тодорхой байх ёстой учраас юу ярихаа маш сайн төлөвлөх хэрэгтэй.
- Бэлтгэсэн үзүүлэнгээ хичээлд сууж байгаа суралцагчдад тарааж өгөх хэрэгтэй бөгөөд энэ нь тэдэнд урьдчилан танилцах боломжийг олгодог.
- Хүний нүд тааламжтай бус фон өнгө сонгохоос татгалзах. Мөн текстийг хэтэрхий уусалттай бичихгүй байх. Ингэвэл суралцагчдын сонирхол буурдаг дутагдалтай.
- Суралцагчдад бодох, эргэцүүлэх цаг хугацааг оновчтой төлөвлөж өгөх хэрэгтэй.
- Хамгийн чухал хэсгүүдээ тодруулж, дэлгэрүүлж байх хэрэгтэй.
- Төлөвлөгдөөгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, урьдаас таамаглах зэргээр бэлтгэлийг хангаж тавьсан асуултанд оновчтой хариулах
- Цахим хэрэглэгдэхүүнээ хэрэглэхийн өмнө хянаж байх. Ингэснээр бусдын өмнө эвгүй байдалд орох зэргээс урьдчилан сэргийлэх.

Судалгаа №1 Сургалтын хэрэглэгдэхүүний сургалтад гүйцэтгэх үүргүүдийг багш хэрхэн харгалзаж, бэлтгэж ашиглаж байгаа, боловсронгуй болгоход анхаарч, сургалтын хэрэглэгдэхүүнийг сургалтад хэрхэн ашиглаж байгаа талаар багш нараас судалгаа авч, дүгнэлт гаргалаа.


Судалгааны зорилго: Хичээлийг үр дүнтэй болгоход нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэх.




Хичээлийг амжилттай заахад юуг хамгийн чухал гэж үздэг вэ?



Та хичээлээ ямар хэлбэрээр түлхүү заадаг вэ?



Та өдөр тутмын хичээл сургалтандаа хэрэглэгдэхүүн хэрэгслүүдээс алийг нь түлхүү хэрэглэдэг вэ?






Та хичээлээ ямар хэлбэрээр түлхүү заадаг вэ? Цахим 35%, Бодит хэрэглэгдэхүүн дээр суурилж гэж 65% нь хариулснаас үзэхэд сургалтын хэрэглэгдэхүүнээ улам боловсронгуй болгож сайжруулах нь багшийн байнгын хүсэл зорилго байх учиртайг харуулж байна.

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт хэрэглэгдэхүүнийг ppt, компьютер, канон, сурах бичиг, ширээ сандал зэргээр ойлгоод байдаг ихэнх мэргэжлүүдэд хичээлд хэрэглэх сурах бичиг байдаггүй учир сургалтын хэрэглэгдэхүүнийг сайн бэлтгэж хэрэглэх нь зүйтэй.

Судалгаа №2

Судалгааны зорилго 2. Хэрэглэгдэхүүн хийхэд зарцуулах хугацааг тооцоолох



Судалгааны дүгнэлт: Дээрх нэгтгүүдээс харахад хэрэглэгдэхүүн бэлтгэхэд их хугацаа зарцуулдаг хэдий ч өдөр тутам хичээлийг хэрэглэгдэхүүнтэй заах, багш бүтээлч байх, хэрэглэгдэхүүнээр хүүхэд бүрийг хөгжүүлэх нь мэргэжлийн




боловсрол эзэмшигчдэд хамгийн чухал гэж үзэж байна.

Судалгаа №3

Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан хичээл сургалтыг зохион байгуулдаг эсэх талаар мэргэжлийн боловсрол эзэмшигчдээс дараах судалгааг авч нэгтгэн үзлээ.

Судалгааны зорилго 3. Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан зохион байгуулсан хичээлийн үр дүн хэр байдгийг тодруулах.



Судалгааны дүгнэлт: Дээрх нэгтгэлээс харахад багш нарын 56.4% нь хааяа л хэрэглэгдэхүүн хэрэглэн хичээл сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулдаг байхад суралцагчид тараах материал, хэрэглэгдэхүүн, ажлын хуудас, цахим хэрэглэгдэхүүн ашиглан зохион байгуулсан хичээл сургалтын үйл ажиллагааг хүсэж байгааг харгалзан үзэж байнга хэрэглэгдэхүүн боловсруулан ашиглаж байх зайлшгүй шаардлага тулгараад байна. Тиймээс хэрэглэгдэхүүн ашиглан зохион байгуулсан хичээл сургалтын үйл ажиллагаа суралцагчдын сонирхлыг



татсан байхаас гадна илүү үр дүнтэй байх нь судалгаанаас харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Сургалтын хэрэглэгдэхүүн нь тухайн хичээлийг үр дүнтэй явуулахад чухал ач холбогдолтой. Багш хичээлийг зохион байгуулахад ямар хэлбэрээр, хэдэн төрлийн хэрэглэгдэхүүнийг ямар сургалтын аргатай хослуулан хэрэглэж, суралцагчдад өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэж, мэдлэг олж авах боломжийг нээн өгч, тэдний чадвар, хэл яриа, сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэг эзэмшүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг болж өгөхийг харгалзах хэрэгтэй.

Эцэст нь тэмдэглэхэд багш нар сургалтын хэрэглэгдэхүүний талаарх мэдлэг мэдээллээ нэмэгдүүлж, улмаар суралтанд оновчтой ашиглах боломжийг эрэлхийлж, түүнчлэн хэр зэрэг үр өгөөжтэй болохийг тодорхойлж, сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, бие даан сурах чадварт суралцуулах бүрэн боломжтойг нарийвчлан тодруулах шаардлагатай юм.

Суралцагчдыг хэрэглэгдэхүүнээр хөгжүүлж чадвал үйлдвэрлэлийн явцын талаар бодох, төлөвлөх, урьчилан төсөөлөх, үнэлэлт, дүгнэлт гаргах, судалгаа хийх, мэдээлэл боловсруулах багаар ажиллах, бүтээлч байх, асуудалд шүүмжлэлтэй хандах, асуудал шийдэх, эргэцүүлэн бодох, шинийг санаачлах чадварууд хөгжиж ажил олгогчийн эрэлтэд нийцсэн ур чадвар бүхий мэргэжилтэнг бэлтгэн гаргах болно.

Багш өөрийн сургах арга барил, хичээлдээ хандах хандлагаа өөрчлөх шаардлага судалгаанаас шууд харагдаж байна. Энэ нь багш мэдлэг чадвар арга барилаа сурагчийн хүсэл сонирхол болон нийгэм цаг үетэйгээ уялдуулан хувиргаж байх шаардлага гарч байна. Багш нар хичээлийн хэрэглэгдэхүүнийг ач холбогдолтойг чухалчилж суралцагчдад эзэмшүүлэхийг зөвлөмжилж байна.

НОМ ЗҮЙ:

- Ичинхорлоо, Ш., “Судалгааны ажлын үндэс” (2009) УБ.,
- Махмут Ачыл “Сурган хүмүүжүүлэх биеийг хэл” (2012) УБ.,
- Пүрэвдорж, Ч., “Багшлахуйн менежмент” УБ.,
- Хандсүрэн “Монголчуудын ёс суртахууны сэтгэлгээ, уламжлал” УБ.,
- Ванчигсүрэн, Д., “Сургалтын технологи” (1992) УБ.,
- <http://www.assa.mn/>
- news.gogo.mn
- www.itpd.mn/
- www.legalinfo

പ്രതി കൗടുംബം 6 രൂപയ്ക്ക് ൧൦ ലിറ്റർ



СУРАЛЦАГЧДЫН СУРЛАГЫН ЧАНАРТ ЦАХИМ ХИЧЭЭЛ НӨЛӨӨЛӨХ ҮҮ?

Багш Ч.Зулзага, З.Цэрэндагва

Оюуны боловсрол бол хүний бас нэгэн эрх чөлөө юм.

Х.Рисаль

Үндэслэл

Хүн төрөлхтний өмнө давагдашгүй хүчин зүйл тулгарч, Covid-19 өвчин дэлхийн ихэнх улс оронд тархснаар цар тахлын хэмжээнд хүрсэн. МУ-ын боловсролын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1 заалт, улсын онцгой комиссын 2020-11-24-ний өдрийн хуралдааны шийдвэр, Хөдөлмөрийн нийгмийн хамгаалын сайдын “Цахим сургалтанд шилжүүлэх тухай ” 2020-11-17-ны өдрийн А/218 дугаар тушаалын дагуу МБС-ийн сургалтын үйл ажиллагааг түр хааж, хичээл сургалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэн суралцагчид гэрээсээ хичээллэх болсон.

Хураангуй

Цахим сургалт гэдэг нь МХХТ-д суурилсан сургалт юм. Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулсны дараа цахим сургалтыг явуулах нь олон давуу талтай байдаг.

Түлхүүр үг

Цахим, танхим, хичээл

Судалгааны зорилго

Компьютерийн хичээлийн чанарт цахим хичээл хэрхэн нөлөөлснийг илрүүлнэ.

Судалгааны зорилт

- Цахим хичээлийн давуу болон сул талыг мэдэх
- Цахим хичээлд хамрагдсан сурагчдын мэдлэг чадварын түвшний ахиц бууралтыг тогтоох
- Цаашид цахим хичээлийг хэрхэн үр өгөөжтэй явуулах арга замыг хайх

Судалгааны ажлын арга зүй

- Ажиглалтын арга
- Харьцуулан дүгнэх арга
- Задлан шинжлэх арга
- Нэгтгэн дүгнэх арга



Судалгааны объект

Тус сургуулийн Мэдээллийн технологи хичээл 10-р анги, ХГД-ны ангийн 45 суралцагчид хамрагдав.


Онолын хэсэг

20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан сургалт зонхилж байсан бол орчин үед электрон сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Цахим сургалт нь сүлжээний технологийг ашиглан засварлах, хүргэх, сонгох, удирдах боломжийг бүрдүүлсэн өргөжүүлсэн хэлбэрээр явагддаг.

Танхимын сургалт нь тогтсон хугацаандаа нэг л удаа заадаг. Энэ нь удаан ойлгодог, мөн янз бүрийн шалтгаанаар хичээлдээ сууж чадаагүй тохиолдолд тухайн хичээлээс хоцрох, ойлгохгүй өнгөрөх нь бий. Тиймээс цахим сургалт нь танхимын учир дутагдалтай талыг нөхөж хичээлийн агуулгыг гэр, сургууль, хаанаас ч компьютер болон гар утаснаасаа үзэх, хичээлд оролцох боломжтой. Багш нар хичээл болон курс зохион явуулах таатай орчинг бүрдүүлсэн байна.


Суралцагчдаас авсан судалгаа

Асуулт 1. Гэртээ компьютерийн хичээл хийх хэцүү байсан уу?




Дүгнэлт: Гэртэй компьютерийн хичээл хийхэд бэрхшээлтэй байсан байна.

2. Теле болон цахим хичээл хийхэд ямар бэрхшээл байсан бэ?





Асуулт 3. Мэдээллийн технологи хичээлийн теле хичээлээ бүрэн үзсэн үү?



Дүгнэлт: Судалгаанаас харахад хүүхдүүд теле хичээлд муу хамрагдсан нь харагдаж байна.

Асуулт 4. Цахимаар хичээллэсний давуу болон сул тал:

Давуу	Сул
Бие даан суралцана Бага цаг зарцуулдаг Нөхөж үзэх боломжтой Техник технологид суралцана Цагт баригдахгүй Өөрийнхөө хурдаар хичээллэнэ Олон хүүхэд цуглахгүй Өвчлөлөөс ангид Халдварын эрсдэлгүй Эцэг эхчүүд хүүхдээ ойлгож хамтран ажиллана Гэрээсээ хол явахгүй	Ойлгохгүй болохоор дутуу хийдэг Давтаж гарахаар үзнэ гэж хойш тавьдаг Гэртээ интернэт байхгүй Хараа муудах, Нөхөж үзэж чадахгүй Хугацаа богино Багаар ажиллах боломжгүй Бусдаас суралцахгүй Харилцааны чадвар нэмэгдэхгүй Амьд харилцаа үүсэхгүй



	Давуу	Сул
Ойлогмжтой	Хөгжлийн үйлчилгээний төв Хичээлд идэвхтэй оролцдог Агуулгаа бүрэн ойлгоно Чанартай хичээл Балштайгаа харилцан ярилцдаг Бие дааж компьютер дээр ажилладаг	Чимээ шуугиан ихтэй Төвлөрдөггүй Эрт босох
Ойлогмоогүй	Ойлогмоогүй зүйлээ асуудаг	

	Сурагчдын нэрс	Анги	танхимын шалгалт	цахим шалгалт	ахисан	буурсан
1	Д.Анхбаяр	10ё	87%	60%		27%
2	Ө.Баясгалан	10ё	77%	50%		17%
3	Э.Буяндорж	10ё	83%	65%		17%
4	Н.Жавхланзул	10ё	80%	70%		10%
5	Б.Жавхланбаяр	10ё	87%	80%		7%
6	М.Золбоо	10ё	63%	80%	17%	
7	А.Марал-Эрдэнэ	10ё	73%	70%	2%	
8	А.Мөнх-Очир	10ё	80%	80%		
9	Б.Наранбат	10ё	87%	80%		7%
10	О.Олз	10ё	90%	60%		30%
11	Оюунгэрэл	10ё	53%	65%	12%	
12	Оюумаа	10ё	87%	65%		12%







ХГД-1 танхимын ба цахим шалгалтын харьцуулалт

	Суралцагчдын нэрс	танхим	цахим
1	Б.Болор-Эрдэнэ	85	65
2	М.Давааням	100	75
3	Ө.Мичидмаа	75	55
4	О.Отгонбат	80	65
5	А.Отгонсайхан	86	75
6	А.Отгонцэцэг	75	60
7	Б.Оюун-Эрдэнэ	80	55
8	О.Санпилдорж	90	65
9	Х.Сугирчулуун	80	75
10	Э.Сүлд-Очир	85	70
11	Б.Сэлэнгэ	70	60
12	Э.Тэмүүлэн	70	60
13	О.Урантогос	95	80
14	Ө.Хатанбаатар	85	70
15	М.Хиймэрсүрэн	65	60
16	Э.Хонгорзул	100	80
17	Э.Цэцэгмаа	100	75
18	Ц.Энхзул	85	65
19	Б.Энэрэл	75	60
20	А.Эрдэнэбаяр	85	55

ХГД-1 танхимын ба цахим шалгалтын харьцуулалт



ХГД-1 танхимын ба цахим шалгалтын харьцуулалт



Дүгнэлт: Дээрх анги тус бүрийн үзүүлэлтүүдээс харахад танхимын хичээлийн оролцоо нь цахимын хичээлийн оролцооноос илүү нь харагдаж байна. Мөн танхимын хичээлийн оролцоо сайтай хүүхдүүдийн цахим хичээлд хамрагдалт, хүлээн авч хэрэгжүүлэх нь сайн байна.

ДҮГНЭЛТ

Боловсрол өөрөө нээлттэй байх ёстой гэсэн үзэл цаг үеэ дагаад цахимд шилжиж байна. Бид 2000аад оноос хойш төрсөн кристал хүүхдүүдтэй ажиллаж байгаа. Дэлхий нийт даяаршиж, техник технологи хурдацтай хөгжиж байгаа өнөө үед тухайн орчиндоо дасан зохицож, сурч боловсроход хөл нийлүүлэн алхах зайлашгүй шаардлага тулгарч байна. Үүнд технологийн дэвшил, өндөр хурдны интернэтийг ашиглаж цахимаар хичээллэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй гэж үзсэн.

Цаашид цахим сургалтын горимд шилжвэл:

- Суралцагчдын сэтгэл зүйг бэлдэх, бие дааж сургах
- Эцэг эх, сурагчидтай хамтран ZOOM, class room гэх мэт програмуудыг утсанд нь суулгах арга, хэрхэн ашиглах аргыг зөвлөмжлөх
- Интернэт орчин бүрдүүлэх
- Хичээл бүрээр теле /цахим хичээл / хичээлийн агуулга арга зүйд суурилсан гарын авлага бэлтгэн сурагчдад тараах

*Найдвар биднийг хөтөлж
Итгэл биднийг зоригжуулдаг*

Ном зүй

- БШУЯ-ны сайт
- Боловсролын тухай хууль
- Ичинхорлоо Ш. Сургалтын онол. УБ. 2012



МОНГОЛЫН
ХАМГААЛ
ЭРХИЙН
МОНГОЛ

Өмнөговь Политехник Коллежийн
багш нарын дунд зохион байгуулсан
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БҮТЭЭЛИЙН ЭМХЭТГЭЛ**

ᠡᠷᠳᠡᠮ ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡᠨᠢ
ᠪᠦᠲᠡᠭᠡᠯᠢᠶᠢᠨ ᠡᠮᠬᠡᠲᠭᠡᠯ



ᠡᠷᠳᠡᠮ ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡᠨᠢ
ᠪᠦᠲᠡᠭᠡᠯᠢᠶᠢᠨ ᠡᠮᠬᠡᠲᠭᠡᠯ